

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

*Техникийн ухааны доктор (Ph.D),
бригадын генерал Д.Ганбаатар*

ТҮҮХ БОЛ ИРЭЭДҮЙН СУУРЬ ҮНДЭС мөн

Монгол Улсын төрөөс хууль хяналтын байгууллагуудын хүний нөөцийн талаар ихээхэн анхаарч өндөр боловсролтой мэргэжлийн дээд /оператив, стратегийн/ түвшингийн боловсон хүчнийг дотооддоо бэлтгэхээр ХСИС-ийн бүрэлдэхүүнд Удирдлагын сургуулийг байгуулсан нь олны талархалыг хүлээж байна. Энэ сургууль нь хил хамгаалах, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдыг тусгай шалгуураар элсүүлэн суралцуулж академийн хэмжээний боловсрол олгохоор ажиллаж эхэллээ. Тус сургууль нь манай улсын боловсролын байгууллагын хувьд дээрхи мэргэжлийн чиглэлээр анхных бөгөөд түүхэнд нэгэн шинэ хуудсыг нээж байгаагаараа онцлог юм.

ХСИС-ийн Удирдлагын сургуулийг байгуулсан нь хэр оновчтой зөв шийдэл болохыг амьдрал батлан, түүх гэрчилнэ. Өнгөрсөн түүх нь үнэнийг өгүүлэх ширгэшгүй ундарга бөгөөд түүх нь амьдралын мөн чанарыг хойч үед түүчээлэн хүргэж, онолыг үүсгэн баталгаажуулдаг билээ.

Тус сургуульд цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас олон сайхан залуучууд сурч байгаагийн дотор хил хамгаалах байгууллагаас ч тодорхой тооны офицерууд суралцаж байна. Монгол Улсынхаа дархан хилийг нүд цавчихгүй хамгаалж, тэр амаргүй хүнд боловч хүндтэй албыг нэр төртэй хашиж байсан, одоо ч үүргээ зохих ёсоор биелүүлж яваа гайхамшигтай сайхан хамт олны дунд ажиллах боломж олдсонд, хилчин хүний хувьд би насан туршдаа бахархаж явдаг билээ.

Улсын хилийн хамгаалалтын найдвартай байдлыг хангахад ар тал техникийн албаны гүйцэтгэсэн үүрэг, энэ албанд ажиллаж байсан үе үеийн хилчдийн гавъяаг үнэлж баршгүй. Түүх болон үлдсэн ахмад хилчдийн ажил амьдралаас сурах зүйл их бий. Монгол цэргийн түүхэн хөгжил нь дэлхийг донсолгож, ертөнцийн чихнээ дуурсагдаж байсан удаатай. Монголчууд цэргийн' урлагийн чиглэлээр дэлхийн түүхэнд томоохон хувь нэмрийг оруулсан талаар манай эрдэмтэд болоод гадаадын эрдэмтэн мэргэд шагшин алмайрч, дэлхийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нь тэмдэглэгдэн үлджээ. Тэртээ алс холын Английн алдарт зохиолч С.Транбул, А.Макбрайд нарын туурвисан “Монголын эзэнт гүрний арми” ном “Монголчуудын цэргийн түүх гэдэг бол магтаалын үг хэллэгийн өвөрмөц хураангуй гэж хэлж болно” хэмээн эхэлжээ. Дэлхийн олон улсын цэргийн түүхэнд ар тал, зэвсэг техникийн хангалт тодорхой байр суурийг эзэлнэ. Улсын хилийн хамгаалалтын ар тал техникийн хангалтын түүхэн замналын талаар өгүүлэхийн урьдал болгон, энэ албаны үүсэл хөгжлийн талаар өөрийн үзсэн багахан зүйлээсээ уншигч Тантай хуваалцахаас эхлэх нь сонин байх болов уу.

Нийтийн тооллын өмнөх 332 онд Македоны Александрын, Египетийн элсэн цөлийг гатлан явуулсан аян дайнд 65000 хүн, ердийн хөсгөнд ашиглаж байсан 8900

уналага бусад амьтдыг хүнс, тэжээл, усаар зохион байгуулалттайгаар тасралтгүй хангаж ялалтыг байгуулсан ажээ. Дэлхийн түүхэнд цэргийн ар талын хангалтын түүхийг энэ үеэс эхлэлтэй гэж үздэг бололтой. Эртний Римийн их гүрний аян дайны үед томхон операц явуулах газраа хүнс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэн ашиглаж байсан нь ялалтад ихээхэн нөлөөлж байсан тухай түүхэнд тэмдэглэгджээ. Тэр үед Римийн хээрийн армийн хүн хүч 70000-80000-д хүрч байжээ.

Юлий Цезарийн Белгийг эзлэн авах дайны үед усаар хангалтаа зохион байгуулж байсан. Харин Белгүүд өлсгөлөнд нэрвэгдэж өөр өөрийн овог аймагт тарж очсон тул Юлий Цезарт хэсэг тус бүрээр нь бут цохих боломж бүрдсэн гэнэ. Нийтийн тооллын өмнөх 3 дугаар зуунд манай өвөг дээдэс Хүн /Хүннү/ гүрний их хаан Модуны үед цэрэг арми аравт, зуут, түмтийн системийн зохион байгуулалтад орж цэрэг даргыг хувцас /малгай/-аар нь ялгадаг байсан тухай эрдэмтэн зохиолч Г.Сүхбаатар “Монгол түүхийн дээж бичиг” цуврал бүтээлдээ тэмдэглэсэн бөгөөд хүнс, хувцасны хангалт ч энэ үеэс зохион байгуулалтад шилжих суурь тавигдаж, цэргийн ар талын хангалтын эхлэл үүссэн гэж үзэх үндэслэлтэй ажээ.

Дундад зуунд Франкийн Их хаан Карлын /742-814/ үед цэргүүд аян дайнд мордохоор цугларах төвд ирэхдээ хүн бүр хувиасаа 3 сарын хүнсний нөөцтэй ирэх ёстой байж. Тиймийн учир дайныг богино хугацаанд явуулдаг байв. Монголын их эзэн богд Чингис хаан /1167-1227/, түүний алтан ургийн хаадын үеийн аян дайны цэргийн ар талын хангалтын түүх нь дэлхийн олон улсын түүхэнд томоохон орон зайг зүй ёсоор эзэлдэг тухай Оросын түүхч, зохиолч А.Г.Мерниковын “Эртний ертөнцөөс өнөөдрийг хүртлэх дайны түүх” /2007 он/, Английн зохиолч С.Транбул, А.Макбрайд нарын “Монголын эзэнт гүрний арми” ном бүтээлүүдэд тодорхой бичсэн байна.

Орчин үеийн цэргийн ар талын хангалт нь XVI зуунд хүнсний төвлөрсөн хангалт /агуулах/ орос, англи, испани, францын армид үүссэнээс эхлэлтэй гэх нь бий. XIX зуунд франц /Наполеон/-ын арми үе шаттай хангалтыг хэрэглэж эхэлсэн. Байлдаан явагдаж буй хэсгүүдийн гол чиглэлд 30-40 км тутамд нөхөн хангалтын цэг /гутал, хувцас, хүнс, эмнэлэгийн үйлчилгээ/ байдаг байжээ. Европын орнуудад 19 дүгээр зууны дунд үеэс цэрэг дайны ажиллагаа, ар талын хангалтад төмөр замыг ашиглаж эхэлсэн байна. XX зууны эхэн үеэс төмөр зам, автомашин, усан болон агаарын тээврийг өргөн ашиглаж иржээ.

Цэргийн ар тал техникийн хангалтын түүхийн үүсэл хөгжлийн хэсгийг үүгээр товчлон Хил хамгаалах байгууллагын ар тал техникийн хангалтын албаны түүхэн замнал, орчин нөхцөлд анхаарал татсан зарим асуудлын талаар өөрийн мэдэх багахан зүйлийг залуу үедээ сургамж болгон хуваалцахыг зорив. Улсын хилийн хамгаалалтын хөгжлийн салшгүй хэсэг нь түүний ар тал техникийн хангалтын түүх билээ. Хилийн цэргийн ар тал техникийн алба нь улсын хилийн хамгаалалтын хангалт үйлчилгээг зохион байгуулж, түүнийг бэхжүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлж ирсэн түүхтэй. Орчин үеийн Хил хамгаалах байгууллагын ар тал техникийн хангалтын түүхийг улс орны хөнжлийн онцлог үеүдтэй холбон судалж үзэхэд дараах байдлаар бүлэглэж болохоор байна. Үүнд:

1. Хил хамгаалах байгууллагын ар тал, техникийн хангалтын алба үүсэж хөгжсөн үе /1933-1944 онд/

- Хилийн цэрэг байгуулагдсан үеэс түүний хангалт үйлчилгээг хариуцсан төрөл мэргэжлийн албадууд байгуулагдаж эхэлжээ;

- Монгол Улсын төрөөс хил хамгаалалтын ар тал, техникийн хангалт үйлчилгээг үүсгэж хөгжүүлэхдээ ЗХУ-ын /хуучин нэрээр/ онол, практикийн тусламжийн үр дүнд үндэслэжээ;

2. Дайны үеийн ар тал, техникийн хангалт/1944-1951 он/

- Дайны цагт улсын хилийн хамгаалалтыг зохион байгуулж явуулах түүний хангалт үйлчилгээг Монгол Улсын төрөөс анхаарч төрийн бодлого болгон хэрэгжүүлсэн;

- Хил хязгаарын онцлог түгшүүртэй оперативын чиглэлд хүч хэрэгслийг бүлэглэн төвлөрүүлсэн;

- Зэвсэг галт хэрэглэл, материал хэрэгслийн нөөцүүдийг цувраажилтаар зохион байгуулсан, орон нутагт хилийн отряд дундын нөөцийн агуулахуудыг байгуулж хангалтыг фронтод ойртуулсан;

- Хангалт төвөөс застав, фронт хүртэл цувраажилтаар хангагдаж байсан бөгөөд их хэмжээний материал, ялангуяа галт хэрэглэл, шатахуун зарцуулагдаж байсан тул Зөвлөлтийн армийн туршлагаар хэмжих нэгжийг байлдааны үеийн хангалтын тооцооны нэгжээр тооцох эхлэл гарч байсан;

- Автомашин техникуудийн бэлэн байдлыг ханган, засварлаж нөөцлөн, фронтод шаардлагатай ачааг төвлөрсөн хангалтаар тээвэрлэх ажилд бүхнийг зориулж байсан;

3. Хүйтэн дайны үеийн ар тал, техникийн хангалт /1967-1990 он/

- Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлөөс бий болсон социалист капиталист системийн зөрчил өрсөлдөөн болон өмнөд, умард хоёр хөршийн улс төрийн таагүй харьцаа нь Монгол оронд нөлөөлж улсын хилийн хамгаалалт түүний хангалт үйлчилгээнд онцгой байдал үүссэн;

- Болзошгүй дайнд бэлтгэж их хэмжээний нөөц хуримтлуулсан;

- Социалист системийн орнуудын, ялангуяа ЗХУ-ын буцалтгүй тусламжийн нөлөөнд цэргийн хангамжийн үлэмж хэсэг нь гадны ивээлд байсан;

4. Зах зээлийн үеийн хил хамгаалах байгууллагын ар тал, техникийн хангалт /1990-2013 он/

- Терроризмын (алан хядах) ажилдгааны үед болон хилийн болзошгүй зөрчлийн нөхцөлд шаардагдах албаны бэлэн байдлын нөөцийг бүрдүүлж хадгалах;

- Эдийн засгийн хязгаарлагдмал боломжид бие дааж хангалтыг зохион байгуулах шаардлагатай болсон зэрэг онцлогтой болно.

Хил хамгаалах байгууллагын ахмад ажилтнуудын үеийн үед өртөөлөн буухиалж хойч үедээ дамжуулж ирсэн зүтгэл бүтээл нь түүхийн үнэт өв, мартагдашгүй сургамж билээ. Энэ талаар түүхийн ухааны доктор, дэд профессор Э.Лувсанбалдангийн “Зүтгэл бүтээлийн он жилүүд” /2005 он/, ахмад хилчин Г.Цэдэвдоржийн “Хилийн цэргийн ар тал инженер техникийн албаныхан” /2008 он/, Монгол Улсын Соёлын гавъяат зүтгэлтэн, хурандаа И.Төмөрбат агсны “Буян хурсан буурал андууд” /2003 он/ зэрэг ном бүтээлүүдэд тодорхой тусгагдсан байна.

ХХЕГ-ын удирдлага нь 2000 оноос улсын хилийн бүсчилсэн хамгаалалт, 2007 оноос гэрээт хилчдийн хүчээр хил хамгаалалтыг зохион байгуулж явуулах

бодлогыг идэвхтэй хэрэгжүүлж эхэлсэн билээ. Үүнтэй холбогдуулан улсын хил хамгаалалтын ар тал, техникийн хангалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулж явуулах, хилийн бүсчилсэн хамгаалалтын шинжлэх ухааны үндэслэлийг гаргахын тулд хилчдийн энерги /илчлэг/ зарцуулалтыг тодорхойлох судлагааны ажлыг Анагаах ухааны хүрээлэнгийн “Хүн судлалын үндэсний төв”, “Шинжлэх ухаан технологийн сан”, ШУТИС-ын “Хувцас судлалын төв” зэрэг эрдэм шинжилгээний байгууллагуудтай Хил хамгаалах ерөнхий газрын ар тал техникийн албаны мэргэжилтнүүд хамтран “Монгол орны байгаль цаг уурын харилцан адилгүй орчин нөхцөлд албан үүргээ гүйцэтгэж байгаа хилийн цэргийн офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагчдын энерги зарцуулалтын хэмжээг шинээр тогтоож боловсруулах нь” сэдэвт судлагааны ажлыг хоёр жил шахам хугацаанд хийж гүйцэтгэсэн билээ. Энэхүү судлагааны ажилд академич, доктор /Sc.D/ Я.Нямдорж, Ж.Батсуурь нарын зэрэг нэр хүндтэй эрдэмтэд оролцож 2001-2003 онд улсын хилийн зурваст- говь, хээр тал, уулын болон уулархаг бүсийн хилийн отряд застав, харуул хилийн манааг оролцуулан газар дээр нь орчин үеийн хэмжих тусгай хэрэгслийг ашиглаж судлагааны ажлыг явуулсан нь ихээхэн үр дүнтэй ажил болсон юм. Цаг уурын халуун, хүйтэн харилцан адилгүй орчин, говь, тал хээр, өндөр уул, ус намаг, ой мод зэрэг байгалын өвөрмөц нөхцөл байдалд өдөр шөнийн цагийг ялгахгүй хээр хөдөө үүрэг гүйцэтгэж явдаг хилчдийн энерги /илч/ зарцуулалт нь байгалын бүс тус бүрт харилцан адилгүй болохыг судлагаагаар тогтоож, алдагдсан энергийг нөхөх хоолны илчлэг өөр өөр хэмжээтэй байх, хувцасны дулаан хадгалах чанар, халуунд сэрүүн байлгахаас шалтгаалан зарцуулагдах хилчдийн энергийн хэмжээ, үүнтэй уялдан цэргийн албаны үүрэг гүйцэтгэх нөхцлийг хангах хувцасны хийц технологи, өнгөлөн далдлалт тухайн орчинд зохицсон байх шаардлагын бодит дүгнэлтүүд гарсанд энэхүү судлагааны үнэ цэн оршино. Уг судлагааны ажлын үр дүнгээр хүнсний бүсчилсэн хангалтын нормыг 2003 онд, хувцасны бүсчилсэн хангалтын эхлэлийг 2005 онд тус тус Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоолуудаар баталгаажуулсан билээ. Дээрхи сэдвээр “Монгол Улсын хилчдийн энерги зарцуулалт” ном гарсан бөгөөд энэхүү судлагааны ажил нь одоо ч ач холбогдлоо алдаагүй хилчдийн хөдөлмөрийн үнэлгээний үнэт бүтээл хэвээр байна. Хил хамгаалах байгууллагын ар тал техникийн хангалтын албаны түүхийг судалж үзэхэд тус алба нь өдөр тутмын хилийн хамгаалалтын хангалт үйлчилгээг зохион байгуулахын зэрэгцээ улсын хилийн хамгаалалтыг бэхжүүлж, хилийн болзошгүй цагийн байдлын хүндрэлтэй нөхцөлд ажиллах бэлтгэлийг хангахад ихээхэн анхаарч, ирээдүйн хөгжлийн суурь үндэс, түүнд хүрэх “гүүр”, “шат”-ыг хойч үедээ тавьж бэлтгэх давхар бодлоготой ажиллаж байсан нь ажиглагддаг. Хилийн хамгаалалтыг бэхжүүлэх ажиллагаанд хил хамгаалах байгууллагын өнөөгийн удирдлага ч ихээхэн анхаарч орчин үеийн шинжлэх ухааны ололт, өндөр технологитой сансарын мэдээллийн техник хэрэгслийг ашиглах зэрэг их зүйлийг хийж байна. Гэхдээ энэ байдалдаа тайвширч, болзошгүй нөхцөлд ажиллах албаны бэлэн байдлыг орхигдуулж хэрхэвч болохгүй. Монгол Улсын төрөөс улсын хилийн хамгаалалтын эрх зүйн болон бусад хангалтад байнга анхаарч ирсний үр дүнд улсын хилийн хамгаалалтын хүчин чадал бэхжиж, хил хамгаалах байгууллага үүргээ зохих түвшинд гүйцэтгэж байна. Гэвч олон улсын алан хядах байгууллагууд, хил дамнасан

гэмт хэргийн бүлэглэлүүд зохион байгуулалтад орж, олон улсын хэмжээнд сүлжээ үүсгэн, үйл ажиллагаа нь идэвжиж, тусгаар улсууд, шударга хүн төрөлхтний эсрэг аюул нүүрлээд байгаа нь нэгэнт бодитой нөхцөл болоод байна. Үүний улмаас зэвсэгт мөргөлдөөн, орон нутгийн шинж чанартай байлдааны ажиллагаа нь өргөжин орчин үеийн дайн болж цар хүрээгээ тэлэх өндөр магадлалтай ажээ. Болзошгүй дайсны хил зөрчсөн бүлэглэлийг устгах, хориглох операци явуулах ажиллагааг тайван цагт урьдчилан харж төлөвлөнө. Зэвсэгт тэмцлийн шинэ хэрэгслүүд гарч, тэдгээрийг байлдааны ажиллагаанд ашиглах болсон өнөөгийн нөхцөлд, өргөн уудам газар нутгийг хамгаалахад ихээхэн хүндрэлтэй байх болно. Үүнтэй уялдаад улсын хил, орон нутгийн хориглон хамгаалалтын үүрэг өсөн нэмэгднэ. Улсын хилийг хамгаалж байгаа хилийн отрядууд нь Зэвсэгт Хүчний нэгтгэлийн хориглох /сөрөг давших/ операци явуулах зурваст байрлан тэдэнтэй хамтран байлдааны ажиллагаа явуулах буюу улсын хилийн өөрийн хариуцсан хэсэгт орон нутгийн чанартай бие даасан байлдааны ажиллагаа явуулж болох юм.

Хил судлалын шинжлэх ухааны онолоор, улсын хилийн хамгаалалтын ар тал хангалтын чиглэлээр тайван цагт албаны бэлэн байдлыг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстойг эрдэмтэд өөрсдийн бүтээлдээ тусгасан нь цөөнгүй ажээ. Үүнд:

- болзошгүй байлдааны ар талын хангалтыг зохион байгуулахын тулд тайван цагт бүрдүүлэх материал хэрэгслийн нөөцийн хэмжээ, бүтцийг тодорхойлох;
- материал хэрэгслийн нөөцийн цувраажилт, хадгалалт, хамгаалалтын журмыг тогтоох;
- хориглолтын район болгохоор хилийн заставуудын тулгуурт байруудыг бат бэх барьж, ашиглалтын бэлэн байдалд байлгах;
- агуулахуудад хадгалагдаж байгаа материал хэрэгслийн нөөцийн хадгалалт, хамгаалалт, өнгөлөн дадлалтыг зохион байгуулах;
- тээвэрлэлт татан гаргалтын замыг бэлтгэх;
- албаны бэлэн байдлын болзошгүй ажиллагаанд отрядын ар талын удирдлагыг зохион байгуулах бэлтгэлийг хангах;
- Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудтай байлдааны ажиллагааны үед ар талын хангалтыг зохион байгуулах асуудлаар харилцан ажиллах зарчмыг тогтоох зэрэг болно.

Эцэст нь улсын хилийн хамгаалалтын хангалт үйлчилгээний ирээдүй, хэтийн төлвийн талаар цөөн үг хэлье. Судалгаанаас үзэхэд, олонхи улсуудын гадаад бодлого нь хөрш зэргэлдээ улс орнуудтайгаа хилээ хамтран хамгаалах, гаалийн олон улсын холбоонд нэгдэх замаар аюулгүй байдлаа бэхжүүлэх, дотооддоо улсын хилийн хамгаалалтад онцгойлон анхаарч бүх төрийн яам, шинжлэх ухааны байгууллагуудын ажлын чиг үүрэгт улсын хил хамгаалалтад шаардлагатай захиалгыг төрөөс хариуцуулан өгч, хил хамгаалах байгууллага нь зөвхөн хил хамгаалах мэргэжлийн үүргээ гүйцэтгэх чиглэлд шилжих жишиг тогтоод байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн арван нэгдүгээр зүйлийн 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал”-ыг хангах нь төрийн үүрэг мөн” хэмээн заажээ. Монгол Улс нь эртний төрт улсын хувьд хилийн хамгаалалт, түүний хангалт үйлчилгээг төрөөс зохицуулж байсан түүхэн

уламжлалтай билээ. Түүнчлэн “Монгол Улсын Хилийн тухай хууль”-ийн хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 2-т “Хилийн хяналтыг явуулахад шаардлагатай барилга, байгууламж, талбай, тэдгээрийн тоног төхөөрөмжийг орон нутгийн болон зам харилцааны байгууллага барьж байгуулсны дараа Улсын хил хамгаалах байгууллага нь хилийн хяналтын бусад байгууллагатай хамтарч тухайн боомтыг нээж ажиллуулна”, мөн хуулийн тавдугаар бүлэг, гучин наймдугаар зүйл, “Төрийн захиргааны төв байгууллагын үүрэг”-ийн 5-д “Төрийн захиргааны төв байгууллага, аж ахуй нэгж нь улсын хилийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, Улсын хил хамгаалах байгууллагад дэмжлэг, туслалцаа үзүүлж, улсын хил хамгаалалтад шаардагдах бүтээгдэхүүнээр тэргүүн ээлжинд хангана” хэмээн тус тус заажээ. Үүнээс үзэхэд улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахад Төрийн захиргааны төв байгууллагуудын шууд оролцоо дэмжлэг туслалцаа чухал ач холбогдолтой байна.

Хол ойрыг холбосон энэхүү сэдвээ үүгээр өндөрлөж, та бүхний аль хэдий нь мэдэх олон зүйлийг нуршиж үнэт цагийг тань үрсэн бол хүлцэл өчье.

*БХИС-ийн Ерөнхий цэргийн тэнхимийн багш,
цэргийн ухааны доктор (Ph.D), дэд профессор,
хурандаа И.Сэржхүү*

ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕД ТӨРИЙН ТУСГАЙ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Хил залгаа улстай хиллэж байгаа хилийн сумдын нутаг дэвгэрийг **хил орчмын нутаг дэвсгэр** гэж үзэх ба сумд нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэгтэй. өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засагтай нийгмийн цогцолбор юм. Энэ нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 25 гаруй хувь буюу, хилийн 14 аймгийн 73 сумын нутаг дэвсгэрийг эзэлж байна.

Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол тухайн бүс нутагт хангагдсан байдлаар тодорхойлогдоно.

Хил орчмын нутаг дэвсгэрт онцгой нөхцөл байдал үүссэн үед тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагааны салшгүй бүрэлдэхүүн хэсгийн нэг болно.

Онцгой байдлын үеийн хил хамгаалалт гэдгийг улсын хилийн зурвас, бүсэд (хил орчмын нутаг дэвсгэрт) гамшигт аюулт үзэгдэл тохиолдох, эмх замбараагүй байдал үүсэх, иргэд бөөнөөр хил нэвтрэхийг завдах, алан хядах, хорлон сүйтгэх ажиллагаа явагдах, өдөөн хатгалга, зэвсэгт халдлага, түрэмгийлэл үйлдэгдэх нөхцөл байдал бий болсон үед хил хамгаалах байгууллагаас явуулах цогц үйл ажиллагаа гэж ойлгоно хэмээн Монгол Улсын хил хамгаалах 11 дүрэм (Хилийн застав)-д тодорхойлсон байна.

Онцгой байдлын үеийн хил хамгаалалт нь олон төрлийн нөхцөл байдлыг агуулсан өргөн цар хүрээтэй асуудал болох нь дүрэмд тодорхойлсноос харагдаж байгаа бөгөөд үүнээс улсын хилээр зэвсэггүй бөөн иргэд цомөрсөн үед хил